

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ТӨСӨӨЛӨЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Судалгааны багийн

гишүүд:

Б.Алтангэрэл

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

М.Хүрэлбат

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

Агуулга

Өмнөх үг		4
Удиртгал		5-8
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙГДСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ /2017-2019/		
1.1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2017-2019 онуудад хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн хэрэглэгчийн үнэлгээнд хийсэн шинжилгээ	9-22
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ		
2.1.	Архангай аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	23-25
2.2.	Баян-Өлгий аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	26-28
2.3.	Баянхонгор аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	29-31
2.4.	Булган аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	32-34
2.5.	Говь-Алтай аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	35-37
2.6.	2.6.Говьсүмбэр аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	38-40
2.7.	Дархан-Уул аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	41-43
2.8.	Дорноговь аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	44-46
2.9.	Дорнод аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	47-49
2.10.	Дундговь аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	50-52
2.11.	Завхан аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	53-55
2.12.	Орхон аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	56-58
2.13.	Өвөрхангай аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	59-61
2.14.	Өмнөговь аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	62-64
2.15.	Сүхбаатар аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	65-67

2.16.	Сэлэнгэ аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	68-70
2.17.	Төв аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	71-73
2.18.	Увс аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	74-76
2.19.	Ховд аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	77-79
2.20.	Хөвсгөл аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	80-82
2.21.	Хэнтий аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	83-85
2.22.	Улаанбаатар хотын иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	86-88
ГУРАВ. УЛСЫН ХЭМЖЭЭНД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ		
3.1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, төсөөлөл	89-92
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ		
4.1.	Дүгнэлт	93-94
4.2.	Зөвлөмж	94

Өмнөх үг

Төрийн байгууллагын ил тод, хариуцлагатай байдлыг хангахад мэдээллийн ил тод байдал нь чухал ач холбогдолтой юм. Аливаа байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ил тод нээлттэй байснаар хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө хангагдах нөхцөл бүрддэг учиртай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн олон талт чиг үүрэг, түүний үр дүнгийн талаар иргэд төдийлөн ойлголт, мэдээлэл багатай байдаг билээ. Нийгмийн амьдралд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар төлбөр төлөгч, төлбөр авагч, ялтан, хоригдол болон тэдний хамаарал бүхий хүмүүс л тодорхой хэмжээний мэдээлэлтэй байдаг гэсэн ойлголт олон жил байсаар ирсэн. Бидний энэ удаагийн судалгаа ч гэсэн энэхүү байгууллагын үйл ажиллагааны талаар дээр дурдсан хамааралгүй иргэдээс ямар мэдээлэлтэй байдаг, тус байгууллагын олон нийтэд чиглэсэн мэдээлэлийн эх сурвалжийн чанар, хүртээмжийн талаар судалхыг зориж энэхүү судалгааны ажлыг хийхийг зорисон болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар олон судалгаа хийгдсэн байдаг хэдий ч тухайлан иргэдийн ойлголт, төсөөллийн талаар хийгдсэн судалгаа үгүй байдаг билээ.

Энэхүү судалгааны мөн нэг онцлог нь Монгол Улсын нийт аймаг, орон нутгийн хэмжээний иргэдийн төлөөллийг оролцуулсан нь судалгааны цар хүрээ, ач холбогдлыг нэмж байгаа юм.

Та бүхэн манай судалгааны ажилтай холбоотой санал, зөвлөмжөө Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвд ирүүлнэ гэдэгт бид найдаж байна.

Бидний судалгааны ажилд оролцсон судлаач магистрант, аймаг орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчдад гүнээ талархал илэрхийлье.

ХҮНДЭТГЭСЭН:

ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР,

ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА


Б.АЛТАНГЭРЭЛ

Удиртгал


Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” –ийн 2.1.5-т “хөндлөнгийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг, 2.1.6-т “хэрэглэгчийн үнэлгээ” гэж захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг хэлнэ гэжээ.

Дээрх хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг хэрхэн сурталчилж, иргэдэд хэрхэн үйлчилгээ үзүүлсэн талаар энэхүү судалгааны ажилдаа тусгахыг хичээсэн болно.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ил тод байдлыг хангах, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг сүүлийн 5 жилийн хугацаанд дараах байдлаар ханган ажилласан байна.



Сүүлийн 5 жилийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим сайтад нийт 874, фейсбүүк хуудаст 775, дотоод мэдээллийн самбарт 542 удаа тус тус мэдээ, мэдээлэл байршуулан ажиллажээ.



Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа хорих анги, байгууллагууд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 413 удаа “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулсан байна.



Иргэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар мэдээлэл авах боломжид судалгаа хийхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим сайтад 2019 онд нийт 265048 буюу өдөрт дунджаар 726 удаа хандалт хийн, мэдээлэл авсан байна.

д/д	Огноо	Нийт хандалтын тоо	Нэг өдрийн хандалтын тоо / дунджаар/
1	2016	250213	686
2	2017	235021	644
3	2018	276504	758
4	2019	265048	726
5	2020.05.25	103427	713

Дээрх судалгаанаас харахад байгууллагын зүгээс нилээдгүй ажил хийж байгаа боловч амьдрал дээр иргэд тус байгууллагын талаар ямар ойлголттой байдаг, үйл ажиллагааг нь хэрхэн үнэлдэг талаар тодруулах зайлшгүй шаардлага байна.

Судалгааны ажлын зорилго:

Судалгааны ажлын зорилгыг иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаарх ойлголт, үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаарх төсөөллийг судлан, цаашид тус байгууллагын үйл ажиллагааг сурталчлахад тус дөхөм болох дүгнэлт-зөвлөмж боловсруулахад явдал мөн гэж тодорхойлсон.


Дээрх зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг өмнөө тавилаа. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн “Хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-гийн үр дүнд шинжилгээ хийх;
2. Аймаг, орон нутгийн хэмжээнд иргэдийн төлөөлөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар судалгаа авах;
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бий болгох хүрээнд холбогдох зөвлөмж гаргах зэрэг болно.


Судалгааны арга зүй:

Энэхүү судалгааны ажлыг хийхэд анкетийн, ярилцлагын болон харьцуулалтын аргыг ашигласан бөгөөд ШШГЕГ-ын олон нийттэй харилцах сурталчлах чиглэлээр хийгдсэн тайлан мэдээг ашигласан болно. Түүнчлэн 21 аймаг тус бүрээс 100 иргэн, Улаанбаатар хотоос 200 иргэн нийт 2300 хүнээс судалгаа авсан. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг харуулбал,


1. Судалгаанд аймаг тус бүрийн харьяат 100, Улаанбаатар хотын харьяат 200, нийт 2300 иргэн хамрагдсан ба судалгаанд хамрагдагсдын 331 буюу 14 хувь нь 18-25, 424 буюу 18 хувь 26-30, 477 буюу 21 хувь нь 31-35, 377 буюу 16 хувь нь 36-40, 313 буюу 14 хувь нь 41-45, 180 буюу 8 хувь нь 46-50, 198 буюу 9 хувь нь 50-аас дээш насны иргэд байсан.



2. Судалгаанд хамрагдагсдын 1047 буюу 46 хувь нь эрэгтэй, 1253 буюу 53 хувь нь эмэгтэй байсан.



3. Судалгаанд хамрагдагсдын 733 буюу 32 хувь дээд, 433 буюу 19 хувь тусгай дунд, 767 буюу 33 хувь нь бүрэн дунд 233 буюу 10 хувь нь бүрэн бус дунд, 86 буюу 4 хувь нь бага боловсролтой, 38 буюу 2 хувь нь боловсролгүй байсан.



4. Судалгаанд хамрагдагсдын 551 буюу 24 хувь нь төрийн алба хаагч, 527 буюу 23 хувь нь хувийн хэвшлийн алба хаагч, 628 буюу 27 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 205 буюу 9 хувь нь малчин, 178 буюу 8 хувь нь оюутан, 211 буюу 9 хувь ажилгүй иргэн байлаа.



НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙГДСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ /2017-2019/

1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2017-2019 онуудад хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн хэрэглэгчийн үнэлгээнд хийсэн шинжилгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хуулиар тогтоосон чиг үүргийн хэрэгжилтийг хөндлөнгийн байр сууринаас үнэлэх, үнэлгээний үр дүнд суурилан үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилгоор 2017 онд “Жи Би Эм” судалгаа шинжилгээний байгууллага, 2018 онд “Мянганы өглөө” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага, 2019 онд “Ажиглалт” төрийн бус байгууллагаар тус тус хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж, үр дүнг байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаанд тодорхой түвшинд тусгаж иржээ.

ШШГЕГ-ын үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудад, аж ахуйн нэгжид, иргэдэд болон ял эдлэгсдэд үзүүлж буй үйлчилгээгээр стандартчилалдсан ярилцлага хийх, тухайн үйлчилгээ үзүүлж буй газарт ажиглалт хийж, асуумж авах замаар мэдээлэл цуглуулан үнэлгээ хийсэн байна.

1. Түүврийн хэмжээ

-2017 онд нийтдээ 3 газраас 110 албан хаагчаас асуумж, хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлэгсэд, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаар үйлчлүүлж буй иргэд, аж, ахуйн нэгж байгууллагын төлөөллийн нийт 250 хүнийг хамруулан асуулга, ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.

-2018 онд нийтдээ 6 газраас 14 удаа ажиглалт хийж, мониторингийн хуудсын бүртгэл хийлгэсэн бөгөөд мөн 200 алба хаагчид болон үйлчлүүлэгчээс анкет асуумж, 52 хүнээс ганцаарчилсан ярилцлага авсан.

-2019 онд нийтдээ 6 газраас 10 удаа ажиглалт хийж, 481 иргэд алба хаагчдаас анкет асуумж, 98 хүнээс ярилцлага авсан.


2. Эрх зүйн орчны үнэлгээ

2017 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан ШШГЕГ-ын үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын тогтоол 1, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон бусад сайд, Улсын ерөнхий прокурортой хамтарсан тушаалаар баталсан 21, ШШГЕГ-ын даргын тушаалаар баталсан 12 эрх зүйн актыг гаргаж, үйл ажиллагаандаа мөрдсөн байна. Эдгээр шинээр мөрдөж буй хууль, тогтоомжуудын хэрэгжилт, уялдаа холбооны талаар судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь хуулийн хэрэгжилт, уялдаа холбоо муу гэсэн дүгнэсэн байна.

3. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017 оныг “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний жил” болгох зорилт дэвшүүлжээ. ШШГЕГ-ын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд телевизээр 48 нэвтрүүлэг, радио нэвтрүүлэг 2, өдөр тутмын болон 7 хоног тутмын сонин хэвлэлээр 61 мэдээлэл, ярилцлага, веб сайт ашиглан 95 мэдээ, мэдээллийг түгээсэн. Мөн www.cd.gov.mn сайтад 168, facebook хуудсанд 185, мэдээллийн самбарт 149, электрон самбар 142 удаагийн мэдээлэл байршуулсан бөгөөд facebook хуудасны онлайн чатаар ирүүлсэн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, сургалтын чиглэлээр асуусан 108 асуултанд цаг тухай бүрт хариу мэдээлэл өгч ажилласан.

Төв архивын баримтаас иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу 263 лавлагаа, 31 тодорхойлолт, 12 цалингийн тодорхойлолт, 168 иргэн, албан тушаалтанд 644 хуудас хуулбар гаргаж өгсөн байна.



2016 оноос 14 хорих анги, 7 шийдвэр гүйцэтгэх алба, 1 шийдвэр гүйцэтгэх хэсэг дээр “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэн, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж, холбогдох үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн. ШШГЕГ-ын “Нэг цонхны үйлчилгээний төв” нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 954 иргэнийг хүлээн авч холбогдох мэдээлэл өгч, хууль зүйн туслалцаа үзүүлсэн бөгөөд хандсан асуудлыг ангилж үзвэл хүний нөөц, бодлогын асуудлаар 112, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр 469, хорих ял эдлүүлэх албаны чиглэлээр 272, бусад асуудлаар 101 иргэн тус тус хандсан байна.


Мөн үйлчлүүлэхээр ирсэн 426 иргэнээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, албан хаагчийн харилцаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авахад дараах үнэлгээг өгсөн байна.



2017 онд ШШГЕГ-т иргэд, хуулийн этгээд, хоригдогсдоос 2516, тус газрын харъяа алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс, салбар нэгжүүдэд 4813, нийт 7329 өргөдөл, гомдол гаргасан байна.

Эдгээрийн 992 нь гомдол, 6232 нь өргөдөл байгаа бол 92 хувь буюу 6754 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу мэдэгдэж, 8 хувь буюу 575 өргөдөл, гомдол хяналтын шатанд хүлээгдэж байна.

Өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл:




Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйлчилгээг 100% буюу 5 оноогоор үнэлсэн байна.

2018 онд ШШГБ өөрийн үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд хэрэхнэ мэдээлэл өгч байгаа болон иргэдийн хувьд шаардлагатай мэдээллээ олж авч чадаж байгаа эсэхэд хийсэн үнэлгээ хийсэн бөгөөд судалгааг явуулахдаа мэдээлэл хүргэж буй арга хэрэгслүүдээс мэдээллийн самбар болон цахим хуудсыг чухалчилж авч үзсэн байна.

Иргэд ШШГБ-ын талаарх мэдээлэл авч буй болон мэдээлэл авахыг хүсч буй хэрэгслийн талаарх судалгааг явуулахад дараах үр дүн гарсан.


/нийт оролцогчдод эзлэх хувиар/



Мэдээллийн самбараас өөрт хэрэгтэй мэдээллийг олж авч чаддаг уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдагсдын 5,1 хувь нь авсан, 51,4 хувь нь аваагүй, 43,5 хувь нь мэдээлэл авахыг хүссэн ч шаардлагатай мэдээлэл байгаагүй гэсэн хариултыг өгсөн байна.

Байгууллагын цахим хуудсанд хандалт хийж байсан эсэх талаар судалгаанд оролцогчдын 54 хувь нь хийж байсан, 46 хувь хийж байгаагүй гэсэн хариултыг өгчээ. Веб сайтад хандалт хийсэн иргэдийн 61,2 хувь нь анхан шатны мэдээлэл хаяг байршил, утасны дугаар, онлайн туслах гэх мэт мэдээлэл авахаар, 24,1 хувь нь бүрдүүлэх материал харах, төлбөрийн мэдээлэл авах, илгээхээр, 15 хувь нь бусад шалтгаанаар хандсан байна. Мөн судалгааны дүнгээр үйлчилгээний цар хүрээ, давтамж, хэрэгцээ шаардлагаас үүдэн НШШГГ-ын цахим хуудас болох www.niislel.gov.mn сайтад иргэд түлхүү ханддаг нь ажиглагдсан.

Тэгвэл цахим хуудсанд хандаад хүссэн мэдээллээ авч чадсан уу гэсэн асуултад хариулсан байдлаас харахад иргэд цахим хуудасны мэдээллийг ашиглах тал дээр иргэд төдийлөн хангалттай сайн биш байгаа нь харагдаж байна.



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 35 хувь нь лавлагаа, зөвлөгөө мэдээлэл өгөх утсаар үйлчлүүлж байсан, 28,7 хувь нь лавлагаас цаашид мэдээлэл авахыг хүсч байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд чухал мэдээллийн эх сурвалж болох боломжтой гэдгийг харуулж байна.

2019 оны хэрэглэгчийн үнэлгээний тайланд мэдээллийн самбараар болон цахим хуудас /www.cd.gov.mn, www.niislel.gov.mn/ -ыг ашиглан иргэдэд мэдээллийг хэрхэн хүргэж буй талаар голчлон судалгаа явуулсан байна.


Уг судалгаагаар ШШГБ-ын үйл ажиллагааг ихэнх тохиолдолд тухайн хариуцсан шийдвэр гүйцэтгэлийн ажилтан, алба хаачаас ирж авах, гар утсаар нь холбогдож мэдээлэл хүсдэг гэж хариулсан байна. Мөн нийт иргэдийн 50,9% нь өмнө нь ямар нэг мэдээлэл авахгүйгээр тухайн байгууллагад очиж ханддаг, тухайн шийдвэр гүйцэтгэлийн ажилтантай шууд холбогддог гэж хариулсан бол 49,1% нь бусад мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл авдаг гэж хариулсан байна.

Түүнчлэн судалгаанд хамрагсдын 60% нь мэдээллийн самбараас мэдээлэл авахыг хүсдэг ч шаардлагатай мэдээлэл байгаагүй гэж хариулсан бол 40% нь завгүй учир ажилтанд шууд хандах нь хялбар гэсэн хариултыг өгсөн байна.

Иймд цаашид цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан мэдээллийг хүргэхийн тулд иргэдэд зориулсан мэдээлэл, сургалтын үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Мөн ШШГБ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах сувгийн талаар иргэдээс авсан санал асуулгад телевизээр 31 буюу 6,4%, интернетээр 76 буюу 15,6%, FM радиогоор 9 буюу 1,8%, бусад иргэдээс 93 буюу 19,1%, зураг хуудсаар 28 буюу 5,7%, байгууллагын ажилтнаас 174 буюу 35,7%, мэдээллийн самбараар 32 буюу 6,6%, утсаар 8 буюу 1,6%, огт авдаггүй гэсэн хариултыг 27 буюу 1,8%, бусад гэсэн хариултыг 9 буюу 1,8% нь өгсөн байна.

Мэдээллийн ил тод, ойлгомжтой байдал нь үйлчилгээний чанар, иргэдийн сэтгэл ханамжид онцгой нөлөөтэй бөгөөд иргэдээс авсан санал асуулгаар ШШГБ-ын мэдээллийн ил тод, ойлгомжтой байдалд 49% нь маш сайн, 48,3% нь сайн, 25% нь дунд, 15,6% нь муу гэсэн үнэлгээг өгчээ.




Эдгээр үзүүлэлтийг нэгтгэн шинжилгээ хийж, 2019 онд ШШГБ-ын мэдээллийн ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй байдлыг 70% буюу 3,5 оноогоор үнэлсэн байна.

3. Үйлчилгээний чанарын үнэлгээ


2017 оны 06 дугаар сард “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийг шинэчлэн баталсны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/198 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчилсэн. 2017 онд 3184 орон тоо батлагдсанаас 3029 алба хаагч ажиллаж байна. Үүнд 1224 офицер, 1484 ахлагч, 306 энгийн алба хаагч байна.

2017 онд үйлчилгээний чанарын үнэлгээг SWOT/TOWS матриц, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд алба хаагчийн шилжилт хөдөлгөөн хэрхэн нөлөөлдөг эсэх энэхүү нөлөөлөлд хийсэн корреляцийн шинжилгээ, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар алба хаагч, хоригдол болон иргэдээс авсан санал асуулга зэргээр тодорхойлсон байна.


Санал асуулгад 112 ШШГБ-ын албан хаагч, 100 хоригдол, 60 хохирогч болон иргэд, нийт 272 хүнээс санал асуулга авахад дараах үнэлгээг өгсөн байна.




2018 онд ШШГБ-ын иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг тодорхойлох үүднээс нийт 5 асуулт бүхий асуулгыг 200 иргэдээс авч үр дүнг нэгтгэсэн байна.




2. Тантай ээлдэг таатай харилцсан уу?




3. Ажилтны боловсрол мэдлэг ямар байсан бэ?



4. Ажилтны шударга байдал ямар байсан бэ?



5. Ажилтны хариуцлагатай байдал ямар байсан бэ?



Дээрх үзүүлэлтийг НШШГГ болон хорих ангиар ялган багцалж авч үзвэл хорих ангиар үйлчлүүлсэн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар сайнаас маш сайн, НШШГГ-аар үйлчлүүлэгчдийн хувьд дунд зэрэг сайн гэсэн үнэлгээтэй байна.

Мөн судалгаанд хамрагдагсдаас авсан нэмэлт судалгааны үр дүн дараах байдалтай байна.

д/д	Асуулт	Хариулт
1	ШШГБ таньд шаардлагатай үйлчилгээг үзүүлж чадсан уу?	Хангалттай 91% Дунд 7% Мэдэхгүй 2%
2	Таны одоогийн авч буй үйлчилгээ бүрэн шийдвэрлэгдсэн үү?	Бүрэн шийдвэрлэгдсэн 100%
3	ШШГБ-ын алба хаагч таньд үйлчилгээ үзүүлэхдээ албаны нэрээр далайлган сурдүүлэх, зүй бус харьцах тохиолдол гаргасан уу?	Үгүй 100%
4	Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд хэдэн ажилтанд хандсан бэ?	1 ажилтан 100%
5	Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд 1 ажилтанд олон удаа хандах тохиолдол гарсан уу?	Тийм 78,6% Үгүй 21,4%
6	Нэг ажилтанд дахин хандсан үйлчлүүлэгчдийн хандсан асуудлыг авч үзвэл	ШШГА, ШГ-тай холбоотой 78,6 Бусад үйлчилгээтэй холбоотой 21,4
7	ШШГБ-ын ажилтнуудын мэргэжлийн үр чадвар, хууль хэрэглэх чадварыг үнэлнэ үү?	Маш сайн 84% Сайн 16%
8	Та энэ байгууллагын үзүүлж буй үйлчилгээнд сэтгэл хангалуун байна уу?	Маш их сэтгэл ханамжтай 89% Сэтгэл ханамжтай 11%
9	ШШГБ-ын үйл ажиллагаанд та ямар үнэлгээ өгөх вэ?	Маш сайн 91% Сайн 9%

Мөн үйлчилгээний чанарыг тодорхойлох бас нэгэн үзүүлэлт бол ажилтан, албан хаагчдын харилцааны соёлын асуудал юм. Судалгаанд оролцогчдын олонх нь буюу 70-аас дээш хувь нь хорих ангийн ажилтнууд өөртэй нь эелдэг таатай харьцаж, хүнд сурталгүй, шуурхай, чирэгдэлгүй үйлчилсэн, холбогдох зөвлөгөө мэдээлэл өгсөн гэж үзсэн байна. 2018 онд ШШГГГ дээр хийгдсэн сэтгэл ханамжийн судалгаатай танилцан үзэхэд нийт 397 иргэнээс “Сэтгэл ханамжийн үнэлгээний хуудас”-аар анкет судалгаа авсан ба 36,7% нь ШГА-г түргэн шуурхай, нээлттэй байлгах тухай, 22,4% нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн

мэдээллийн хэрэгслээр нээлттэй хүргэж байх тухай санал хүсэлт гаргасан бол, 40,9 хувь нь ямар нэгэн саналгүй гэсэн байна.

2019 онд ШШГБ-ын иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг тодорхойлох үүднээс нийт 5 асуулгаар 680 иргэнээс авч үр дүнг нэгтгэсэн байна.

д/д	Асуулт	Хариулт				
		Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Мэдэхгүй	Муу
1	Таньд бусадтай адил тэгш үйлчилсэн үү?	19%	62%	16%	13%	
2	Таньтай эелдэг таатай харилцсан уу?	29%	61%	10%	0%	
3	Ажилтны боловсрол, мэдлэг ямар байсан бэ?	16%	84%	0%	0%	
4	Ажилтны шударга байдал ямар байсан бэ?	5%	61%	10%	21%	3%
5	Ажилтны хариуцлагатай байдал ямар байсан бэ?	62%	31%	7%	0%	

Үүнээс үзэхэд ШШГБ-аар үйлчлүүлсэн иргэд үйлчилгээний чанарыг маш сайн, сайн гэж үнэлсэн нь харагдаж байна.

Мөн НШШГГазар болон хорих ангийн судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдээс авсан дэлгэрэнгүй судалгааны үр дүнг тусгах нь зүйтэй. Энэ нь:

д/д	Асуулт	Хариулт
1	ШШГБ таньд шаардлагатай үйлчилгээг үзүүлж чадсан уу?	Хангалттай 90% Сайн 9% Мэдэхгүй 1%
2	Таны одоогийн авч буй үйлчилгээ бүрэн шийдвэрлэгдсэн үү?	Бүрэн шийдвэрлэгдсэн 100%
3	ШШГБ-ын алба хаагч таньд үйлчилгээ үзүүлэхдээ албаны нэрээр далайлган сурдүүлэх, зүй бус харьцах тохиолдол гаргасан уу?	Үгүй 100%
4	Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд хэдэн ажилтанд хандсан бэ?	1 ажилтан 99%
5	Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд 1 ажилтанд олон удаа хандах тохиолдол гарсан уу?	Тийм 80,1% Үгүй 19,9%
6	Нэг ажилтанд дахин хандсан үйлчлүүлэгчдийн хандсан асуудлыг авч үзвэл	ШШГА, ШГ-тай холбоотой 78,6% Бусад үйлчилгээтэй холбоотой 21,4%

7	ШШГБ-ын ажилтнуудын мэргэжлийн үр чадвар, хууль хэрэглэх чадварыг үнэлнэ үү?	Маш сайн 94% Сайн 6%
8	Та энэ байгууллагын үзүүлж буй үйлчилгээнд сэтгэл хангалуун байна уу?	Маш их сэтгэл ханамжтай 91% Сэтгэл ханамжтай 9%
9	ШШГБ-ын үйл ажиллагаанд та ямар үнэлгээ өгөх вэ?	Маш сайн 89% Сайн 11%
10	Иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ ШШГБ-ын ажилтнуудын хоорондын уялдаа холбоо	Маш сайн 7% Сайн 58 % Дунд 28% Муу 6,8%

Дээрх санал асуулгын үр дүнд шинжилгээ хийж 2019 онд ШШГБ-ын үйлчилгээний чанарыг 74% буюу 3,7 оноогоор үнэлж, дунджаас дээгүүр оноотой буюу “сайн” гэсэн үнэлгээг өгч байна.


Мөн 2019 оны хэрэглэгчийн үнэлгээний тайланд ШШГБ-аас үйлчилгээ авсан иргэдэд ажил үүргээ гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудын зан араншин, ёс зүйн байдал хэрхэн нөлөөлдөг, энэ асуудал анхаарал хандуулдаг эсэх талаар судалгаа явуулж дүгнэлт боловсруулжээ. Энэхүү судалгаагаар үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудын иргэдтэй харилцаж буй байдал, иргэдийн хүлээлтэнд нийцэж байгаа эсэх, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж чадаж байгаа эсэх, иргэдийн асуултанд хариулах, мэдээллийг өгч байгаа байдал, үйлчилгээ үзүүлсэн үр дүн, нөлөөг тодорхойлохыг зорьсон бөгөөд нийт санал асуулгад оролцсон иргэд, алба хаагчдын ёс зүйн үзүүлэлтэд 4,0 оноо өгсөн нь хангалттай сайн гэж үзэж болно.

4. Үйлчилгээний хүртээмжтэй байдлын үнэлгээ

а/ Төлбөр барагдуулах үйлчилгээний талаарх хэрэглэгчийн үнэлгээ: 2017 онд Шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор орон нутаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба, хэсгийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 21 шийдвэр гүйцэтгэгчийг иргэний хэргийн шийдвэртэй гүйцэтгэх баримт бичигт татан ажиллуулахаар шийдвэрлэж, мөн ХСИС-ийн ШШГС-ийн II, III дамжааны сонсогчдыг 2 сарын хугацаанд амралтын өдрүүдээр нийслэл дэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд татан оролцуулсан зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллажээ.


Шийдвэр гүйцэтгэгчийг төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллээр шуурхай хангах, төрийн байгууллагын ажлын ачаалал, зардлыг бууруулахаар мэдээлэл солилцох ажиллагааг онлайн хэлбэрээр явуулж, “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн систем”-д гүйцэтгэх баримт бичгийн мэдээллийг бүртгэж, цахим бүртгэлийн нэгдсэн сан үүсгэсэн.

2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 39405 /эрүү, иргэн, захиргаа, бусад/ гүйцэтгэх баримт бичгийн 1448,3 тэрбум төгрөгийг биелүүлэхээс 19648 гүйцэтгэх баримт бичгийн 294,9 тэрбум төгрөгийг бодитой биелүүлж, 19757 гүйцэтгэх баримт бичгийн 1153,4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.



Төлбөртэй ялтны төлбөр барагдуулалт 2017 оны жилийн эцсийн байдлаар 1683 гүйцэтгэх баримт бичгийн 17,3 тэрбум төгрөгийн төлбөрөөс 526 гүйцэтгэх баримт бичгийн 1,1 тэрбум төгрөгийг биелүүлж 1157 гүйцэтгэх баримт бичгийн 16,2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төлбөр барагдуулах үйлчилгээний талаар иргэдийн дунд явуулсан санал асуулга болон ярилцлагын судалгааны дүнгээс харахад, тэдний сэтгэл ханамж төдийлөн сайн биш байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь буюу 52,9 хувь нь шийдвэр гүйцэтгэх албанаас үзүүлж буй төлбөр барагдуулах үйлчилгээг удаашралтай явагддаг гэж үзсэн бол 40 хувь нь шуурхай ажилладаг, 7,1 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй гэж хариулсан байна. Төлбөр барагдуулах үйл ажиллагаа удаашралтай байна гэж үзсэн иргэдээс шалтгааныг тодруулах санал асуулга авахад дараах байдлаар хариулсан байна.



Судалгааны үр дүнд шижилгээ хийсний дагуу “Төлбөр барагдуулах үйлчилгээ”-г 87,43 хувь буюу 4,37 оноогоор үнэлсэн байна.

б/ Ялтны ажлын байраар хангах үйлчилгээ: 2017 онд 260 хоригдлын ажлын байр шинээр бий болгож, 3306,9 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 3381 сая төгрөгний борлуулалт хийсэн, гүйцэтгэл 87 хувьтай байна.

Харин 2017 оны жилийн эцсийн байдлаар барилгын материалын үйлдвэрлэлд 115, уул уурхай олборлолт 49, оёдол 638, мод бэлтгэл, модон эдлэл 163, чулуун бүтээгдэхүүн 88, газар тариалан 77, мал аж ахуй 112, гар урлал 144, хэвлэх цех 37, туслах аж ахуйд 1797, гэрээгээр 170, өөрчдийн барьж буй барилгад 93, нийт 3483 хоригдлыг ажлын байраар хангаж ажилласан бөгөөд хөлөдмөр эрхлэлт 62,45 хувь, нийт хоригдлын цалин 414,370.8 мянган төгрөг байна. Хоригдлын шүүхийн төлбөр барагдуулалт нийт 1,0822,521,9 мянган төгрөг, үүнээс өөрийн цалингаас төлсөн 115,618.4 мянган төгрөг байна.

Судалгааны үр дүнд шинжилгээ хийсний дагуу “Ялтны ажлын байраар хангах үйлчилгээ”-г 88,3% буюу 4,42 оноогоор үнэлсэн байна.

2019 онд ШШГБ-ын үйлчилгээний хүртээмжтэй байдлын үнэлгээг иргэдэд хүргэх үйлчилгээг цахимжуулж, мэдээллийн технологийг ашигласан байдлаар тодорхойлсон байна. Тус байгууллагын хувьд үйлчилгээгээ иргэдэд хүргэсэн, үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлсэн тодорхой үр дүнгүүдэд хүрсэн, иргэд өөрт хэрэгтэй баримт бичгийг хүссэн үедээ авч байна гэсэн дүгнэлт гарчээ.

2018 онд ШШГБ-ын иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжтэй байдлыг тодорхойлох үүднээс нийт 7 асуулт бүхий асуулгыг 200 иргэнээс авч үр дүнг нэгтгэсэн байна.

ШШГБ-аар үйлчлүүлэхэд хэр хэцүү байна вэ? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 3, хорих ангийн хувьд 4, дундажаар 3,5 оноогоор, ажиллах өдөр/цаг нь хэр тохиромжтой байдаг вэ? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 4, хорих ангийн хувьд 4, дундажаар 4 оноогоор, өндөх настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд энд үйлчлүүлэхэд хэр тохиромжтой вэ? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 4, хорих ангийн хувьд 5, дундажаар 4,5 оноогоор, тус үйлчилгээг утас, интернет, ТҮЦ машин ашиглан авах боломж байсан уу? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 4, хорих ангийн хувьд 4, дундажаар 4 оноогоор, авч буй үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай байсан уу? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 5, хорих ангийн хувьд 5, дундажаар 4,5 оноогоор, ма материал бүрдүүлэх нь ойлгомжтой байсан уу? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 4, хорих ангийн хувьд 5, дундажаар 4,5 оноогоор, ажилтны тоо хүрэлцээтэй байсан уу? гэсэн асуултад НШШГГ-ын хувьд 3, хорих ангийн хувьд 4, дундажаар 3,5 оноогоор тус тус үнэлжээ.

Дээрх үнэлгээнээс харахад ШШГБ-ын үйлчилгээний чанар НШШГГ-ын хувьд дунд зэргээс сайн, хорих ангийн хувьд сайнаас маш сайн гэсэн үнэлгээтэй байна.

5. Үйлчилгээний орчин нөхцлийн үнэлгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба, газар анги, салбар нэгжүүдийн барилга, байгууламж, ахуй нөхцөлийг олон улсын жишигт хүргэх, шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хангах, нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудад нийцүүлэн ажиллах, материаллаг бааз суурийг үнэлэх хүрээнд 2017 онд 401 дүгээр хорих анги буюу Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хоригдлуудаас тестийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авч үнэлсэн байна.

Хоригдлуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагад нэгээс бусад хоригдлуудын сэтгэл санаа өөдрөг, олон улсын жишиг стандартад нийцсэн гэсэн хариуг өгсөн байна. Судалгааны үр дүнд шинжилгээ хийсний дагуу үйлчилгээний орчин нөхцөлийг 100% буюу 5 оноогоор үнэлсэн байна.

2018 онд иргэдийн үйлчилгээ авч байгаа орчин нөхцөлийг тодорхойлох зорилгоор 5 газрын үйлчилгээний орчин нөхцөлийг ажиглалтын мониторингийн хуудсаар бүртгэж, тухайн газруудаар үйлчлүүлж байсан иргэдээс судалгаа, хоригдлуудаас асуумж, ярилцлага авсан байна. Ингэхдээ үйлчилгээ явуулж буй орчин нөхцөлийг нэгд, гадаад орчин, хоёрт дотоод орчин, гуравт, үйлчилгээтэй холбоотой бусад эд зүйлс, дөрөвт, хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн иргэдийн үйлчилгээ авах орчин гэж 4 ангилан авч үзсэн байна.

Дотоод орчны хувьд сэтгэл ханамжийн болон ажиглалтын хуудасны дүнгээс харахад байгууллагын гэрэлтүүлэг сайн мөн дотоод орчин цэвэрхэн, үйлчилгээний танхимын багтаамж сайн, хүлээлгийн ширээ сандал хангалттай сайн гэж иргэдийн ихэнх нь үзсэн байна.

Гадаад орчны хувьд байгууллагын байршил, хаягжуулалт ойлгомжтой эсэх, машины зогсоол бий эсэх, үйлчилгээ авахад шаардагдах бусад төрлийн үйлчилгээнүүд байгаа эсэхийг судалж үзсэн бөгөөд эдгээр үзүүлэлтийн хувьд хангалттай сайн гэсэн үнэлгээ авсан байна.

Үйлчилгээтэй холбоотой бусад зүйлсийн хэрэгцээг бал, цавуу, үдээс хайч зэрэг туслах материалын хүрэлцээ, маягт зааварчилгаа зэрэг материалын хүрэлцээ хангалттай байгаа эсэх талаар санал асуулгаар тодорхойлсон. Энэхүү асуулгад 15,6% нь маш муу, 32,1% нь дунд, 52,3% нь сайн гэсэн хариултыг өгсөн байна. Үүнээс харахад иргэдэд дутагдалтай байгаа дээрх зүйлсийн хэрэгцээг хэрхэн шийдвэрлэх талаар судалж тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна гэсэн дүгнэлт гаргажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээний хувьд ШШГЕГ-ын харъяа байгууллагуудад хийсэн ажиглалтын дүнгээс харахад харааны


болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан хаягжуулалт мэдээлэл тавигдаагүй, НШШГГ-ын өргөдөл, гомдол хариуцсан мэргжилтэн дохионы хэлний сургалтад сууснаас өөр салбар нэгжийн албан хаагч нар холбогдох сургалт судалгаанд хамрагдсан тухай мэдээлэл алга байна. Мөн судалгаанд хамрагдсан 5 газраас 4 газарт хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдэд зориулсан орц, гарцыг хийсэн, 1 газарт хийгээгүй байна.

2019 онд ШШГБ-ын үйлчилгээг үнэлэхдээ байгууллагын зүгээс иргэдэд үйлчилгээ хүргэж байгаа орчин, түүнийг бүрдүүлж байгаа зүйлсийн талаар үнэлгээ авахад чиглэгдсэн. Энэхүү үнэлгээг өгөхдөө хэрэглэгчдээс үйлчилгээ авч буй орчин, өрөө, танхим, хүлээлгийн өрөө, тэдгээрийн багтаамж, агааржуулалт, гэрэлтүүлэг, цэвэр цэмцгэр байдал зэрэг нь стандарт, үйлчилгээний нөхцөлд нийцэж байгаа эсэх талаар асуулга авсан. Санал асуулгаас гарсан үр дүнд шинжилгээ хийж, ШШГБ-ын үйлчилгээний орчныг 4,0 оноо буюу үйлчилгээний орчны бүрдүүлэлт сайн бүрдсэн гэж дүгнэсэн байна.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

2.1. Архангай аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ


1. “Та шүүхээс гарсан шийдвэрийн хэрэгжилт ямар түвшинд хэрэгждэг гэж үздэг вэ” гэсэн асуултад 30 хувь нь сайн хэрэгждэг, 30 хувь нь дунд зэрэг хэрэгждэг, 24 хувь нь муу хэрэгждэг, 16 хувь нь огт хэрэгждэггүй гэж хариулжээ.




2. “Та шүүхийн шийдвэрийг хэрэгжилтийг нэмэгдүүлэхэд юун дээр анхаарах нь зүйтэй гэж үздэг вэ” гэсэн асуултад 21 хувь нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, 40 хувь нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, 17 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, 14 хувь нь иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, 8 хувь нь шүүхээс гарч буй шийдвэр нь бодитой, хэрэгжих боломжтой байх гэж хариулжээ.




3. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлж байсан уу” гэсэн асуултад 25 хувь нь тийм, 75 хувь нь үгүй гэж хариулжээ.




4. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хэрхэн үнэлж байна вэ” гэсэн асуултад 35 хувь нь сайн, 61 хувь нь дунд, 4 хувь муу гэж хариулжээ.




5. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар ямар төсөөлөлтэй вэ” гэсэн асуултад 13 хувь нь хорих байгууллага, 15 хувь нь өр төлбөр барагдуулдаг байгууллага, 56 хувь нь шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэдэг байгууллага, 13 хувь нь сайн мэдэхгүй гэж хариулжээ.




6. “Та хорих ангид ял эдэлж буй хоригдол нийгэмшиж буй байдлыг хэрхэн үнэлдэг вэ” гэсэн асуултад 55 хувь нь сайн нийгэмшиж, хүмүүждэг, 35 хувь нь дунд зэрэг, 10 хувь нь огт нийгэмшиж, хүмүүжихгүй байна гэж хариулжээ.




7. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр, хохирол барагдуулж буй үйл явцыг та хэрхэн үнэлэх вэ” гэсэн асуултад 30 хувь нь сайн, 51 хувь нь дунд, 19 хувь нь муу гэж хариулжээ.



8. “Хорих байгууллагад хүний эрхийг хэрхэн хангадаг гэж та боддог вэ” гэсэн асуултад 26 хувь нь сайн, 54 хувь нь дунд, 20 хувь нь муу гэж хариулжээ.




9. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаарх мэдээллийг та мэдээллийн аль эх сурвалжаас авдаг вэ” гэсэн асуултад 47 хувь нь телевизийн мэдээ, 12 хувь нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын вебсайт, 12 хувь нь facebook, 8 хувь нь интернет орчин, 8 хувь нь сонин, хэвлэл, 6 хувь нь хүмүүсийн яриа, 7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.



10. “Шүүхээс гарсан шийдвэр нь бүрэн биелэгдсэнээр ямар ач холбогдолтой гэж та үзэж байна вэ” гэсэн асуултад 12 хувь нь хүний зөрчигдсэн эрх сэргээгдэнэ, 11 хувь нь гэм буруутай хүнийг цээрлүүлнэ, 22 хувь нь хохирсон хүн хохирлоо барагдуулна, 25 хувь нь нийгэмд шударга ёс тогтоно, 30 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.




11. “Танд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломж хэр зэрэг байдаг гэж боддог вэ” гэсэн асуултад 8 хувь нь сайн, 59 хувь нь дунд, 20 хувь нь муу, 15 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.



2.2.Баян-Өлгий аймгийн иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ


1. “Та шүүхээс гарсан шийдвэрийн хэрэгжилт ямар түвшинд хэрэгждэг гэж үздэг вэ” гэсэн асуултад 40 хувь нь сайн хэрэгждэг, 23 хувь нь дунд зэрэг хэрэгждэг, 30 хувь нь муу хэрэгждэг, 7 хувь нь огт хэрэгждэггүй гэж хариулжээ.




2. “Та шүүхийн шийдвэрийг хэрэгжилтийг нэмэгдүүлэхэд юун дээр анхаарах нь зүйтэй гэж үздэг вэ” гэсэн асуултад 14 хувь нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, 40 хувь нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, 29 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, 1 хувь нь иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, 16 хувь нь шүүхээс гарч буй шийдвэр нь бодитой, хэрэгжих боломжтой байх гэж хариулжээ.




3. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлж байсан уу” гэсэн асуултад 66 хувь нь тийм, 34 хувь нь үгүй гэж хариулжээ.




4. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хэрхэн үнэлж байна вэ” гэсэн асуултад 60 хувь нь сайн, 30 хувь нь дунд, 10 хувь муу гэж хариулжээ.




5. “Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар ямар төсөөлөлтэй вэ” гэсэн асуултад 52 хувь нь хорих байгууллага, 16 хувь нь өр төлбөр барагдуулдаг байгууллага, 25 хувь нь шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэдэг байгууллага, 7 хувь нь сайн мэдэхгүй гэж хариулжээ.




